**ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ**
**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖҮҮЛЭХ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хот

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв /сая.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар/ | Хэрэг-жилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **Зорилт 2.2.Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ:** | | | | | | | |
| **МУХТЖҮЧ-2.2.1 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | |
| 1 | Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ | 100.0 Улсын төсөв | Нөөцийн төрөл, тоо хэмжээ | 14-30 хоногийн нөөцтэй.. | 2 сарын нөөц бүрдүүлсэн байна. | Эм зүйн албаны эмийн нөөцийн агуулахад ЭМС-ын 2022 оны 06 сарын 20-ны өдрийн 5/2958 тоот тушаалын дагуу нийт 312 нэр төрлийн 145.565.606 төгрөгийн өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис зэрэг хэрэгслүүд 2 сарын нөөцтэйгөөр тусгай хадгалах нөхцлийн дагуу хадгалагдаж байна. | 100% |
| **МУХТЖҮЧ-2.2.2 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.** | | | | | | | |
| 1 | Эх, нярай, эмэгтэйчүүдийн эрт илрүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулна. | 21.0 Өөрийн орлого | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | 2022 оны 05 дугаар сарын 16-наас нярайн кабинет шинээр нээж үйл ажиллагааг эхлүүлснээс хойш 2752 нярайд эрт илрүүлэх хийхэд, зүрхний төрөлхийн гажиг 28, тархины усжилт 2, бөөрний төрөлхийн гидронефроз 2, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тархины ховдлын цус харвалт 3, тархины том хэмжээний уйланхай 2 тус тус эрт илрүүлсэн. Төрөлхийн гаж хөгжлийг эрт илрүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд хамруулсан. Мөн 7241 нярайд түнхний мултралыг илрүүлэх хэт авиан шинжилгээ хийхэд В хэлбэр 312, С хэлбэр 26 илрүүлсэн байна. Сонсголын скрининг 7241 нярайд хийсэн.<br><br>ЭМС-ын 537 тоот тушаалын III-р хавсралтын дагуу урьдчилан сэргийлэх үзлэгээр эмнэлгийн ажилчдын 263 буюу 63.8%-ийг хамруулсан.<br><br>Улирлын томуугийн дархлаажуулалтыг 2022.10.25-26-ны өдрүүдэд явуулж, 220 хүн тун вакцинаар ажилчдын дархлаажуулалт хамруууллаа. | |
| 2 | Жирэмсний хожуу үеийн хордлогыг эрт илрүүлнэ. | | Жирэмсний хожуу үеийн хордлого эрт илрүүлсэн хүний тоо | Байхгүй | Жирэмсний хожуу үеийн хордлоготой 50 хүнийг эрт илрүүлсэн байна. | Эрсдэлтэй жирэмсний тусламжийн тасаг, Амбулаторийн тасгаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдээс 65 жирэмсэн эхийг сонгон жирэмсний 19 долоо хоногтойд манас таталтын урьдчилсэн илрүүлгийн оношлогоог хэт авиан шинжилгээгээр илрүүлсэн. | 100% |
| 3 | Монгол эмэгтэйчүүдийн дунд умайн лейомиомын тархалт, эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх сэдвээр судалгаа хийнэ | 1.0 Өөрийн орлого | Судалгааны тайлан | Байхгүй | Умайн лейомиомын тархалт, эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх судалгаа хийж үр дүнг 100% танилцуулсан байна. | “Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн умайн лейомиомийн өвчлөлд судалгаа хийж илтгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 16-ны эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн. | 100% |

**МУХТЖҮЧ-2.2.3**

**Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Параклиник, Сэргээн засах Уламжлалт эмчилгээний чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлнэ. | 300.0 Өөрийн орлого | Сэргээн засах, Параклиник, Уламжлалт эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо | Байхгүй | Тасаг зохион байгуулж үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тусламж үйлчилгээг 2508 хүнд үзүүлсэн. Цаашид амбулатор болон хэвтүүлэн эмчлүүлэх нэгжийн үйл ажиллагааг эхлүүлнэ. | 100% |
| **МУХТЖҮЧ-2.2.4**<br>**Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.** | | | | | | | |
| 1 | Хүлээн авах хэсгүүдийг нэгтгэж нэгдсэн хүлээн авах тасгаар үйлчлүүлэх боломжтой болгож засвар хийнэ. | 357.0 Улсын төсөв | Хүлээн авах, яаралтай тусламжийн тасаг засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 3 тусдаа хүлээн авах хэсэгтэй | Нэгдсэн хүлээн авах тасаг ашиглалтанд орж үйл ажиллагаа тогтмолжсон байна | Эрүүл мэндийн яамны 357 сая төгрөгийн санхүүжилтээр засварын ажлын зураг төслийг боловсруулж, 3 хэсэгт байршин ажиллаж байсан тасгуудыг нэгтгэн 2022 оны 06 дугаар сараас Нэгдсэн хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн.<br>Нэгдсэн хүлээн авах яаралтай тусламжийн тасаг нь 2022 онд 54777 эхийг хүлээн авч эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 19158 эхийг хэвтүүлэн тусламж үйлчилгээ үзүүлж, 5610 эхэд эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж үйчилгээ үзүүлсэн байна. | 100% |
| 2 | МУХТЖҮЧ-2.2.4 Яаралтай тусламжийн сургалтанд /хөх код/ эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургана. | 3.0 Өөрийн орлого | Мэргэшсэн эмч, эх баригчийн тоо | Яаралтай тусламжийн 2 эмч ажиллаж байна. мэргэшсэн | Яаралтай тусламжийн чиглэлээр 4 эмч, 6 эх баригч мэргэшүүлсэн байна. | 2022 оны 05 дугаар сар, 11 дүгээр саруудад Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран “Амь тэнссэн үеийн зүрх амилуулах тусламжийн сургалт” сургалтыг зохион байгуулж, нийт 27 эмч сургагч багшаар бэлтгэгдэж, 56 эмч, 81 эмнэлгийн мэргэжилтэн 250 гаруй энгийн иргэдийг хамруулллаа. | 100% |
| **МУХТЖҮЧ-2.2.5**<br>**Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.** | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | - | Эрүүл мэндийн даатгалын | Эрүүл мэндийн | Эрүүл мэндийн даатгалын сангаас | Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газраас зохион байгуулсан сонгон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | | сангаас санхүүжилт шинээр авах тусламж, үйлчилгээний төрлийн тоо | даатгалын сангаас 7 тусламж, үйлчилгээний төрлөөр санхүүжилт авч байна. | 10 тусламж, үйлчилгээний төрлөөр санхүүжилт авдаг болсон байна. | шалгаруулалтад 10 тусламж, үйлчилгээний 96 оношийн хамаарлын бүлгээр оролцож зохих шатанд тэнцсэн. Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий газартай тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийн гэрээг 2022 оны 09-р сарын 08-ны өдөр гэрээгээ байгуулан ажиллаж байна. | |
| **МУХТЖҮЧ-2.2.5**<br>**Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| 1 | Эмнэлгийн цахим бүртгэлийн системтэй болно. | 18.0 Өөрийн орлого | Карте цахим бүртгэлд орсон өвчтөний түүхийн тоо | Еклиник 100% нэвтрүүлсэн | Карте цахим бүртгэлд бүх өвчний түүхийг оруулдаг болсон байна | Карте цахим бүртгэлд эхний хагас жилийн байдлаар даатгалаар нэхэмжлэгдсэн 23106 үйлчлүүлэгчийн өвчний түүхийг оруулсан | 100% |
| 2 | Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах CALLPRO үйлчилгээг нэвтрүүлнэ. | | Санал, хүсэлт, гомдол шийдвэрлэлтийн тоо | Утсаар, цаасаар 300 санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн | CALLPRO үйлчилгээгээр 1000 санал, хүсэлт, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна | Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах Callpro компанитай хамтран ажиллах гэрээг 2022 оны 06 дугаар саын 01-ний өдрөөс байгуулан ажиллаж байна.<br>Тус үйлчилгээ нэвтэрснээр Ковид-19 тасгийн тухай 60 үйлчлүүлэгч зөвлөгөө мэдээлэл авсан, Утасны операторын үйлчилгээ буюу callpro үйлчилгээгээр 1087 үйлчлүүлэгчээс дуудлага хүлээн авсанаас 401 нь цаг олголтын дуудлага, 80 нь эмнэлгийн хуудас илгээгдээгүй тухай санал хүсэлт, 96 нь цаг авах талаар, 510 нь зөвлөгөө мэдээлэл өгсөн дуудлага байна. | 100% |
| **2.2.7.эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 1 | Эм зүйч нар UPTODATE ашиглан эмийн эмчилгээнд хяналт тавина. | | UPTODATE ашиглан хяналт тавьсан эмийн эмчилгээний тоо, төрөл | | UPTODATE ашигласан эмийн эмчилгээний хяналт тогтмолжсон байна. | Эмнэлзүйн эм зүйч нар Карте программ дээр орсон эмийн эмчилгээг хянаж эмийн захиалгыг баталж байгаа бөгөөд UPTODATE ашиглан эмчийн бичсэн эмийн эмчилгээг стандартын дагуу байгаа эсэх, нийцэл үл нийцэл байгаа | 85.7% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эсэхийг өдөр тутам нэвтрэн орж хяналтаа тавьж ажиллаж байна. | |
| **2.2.8.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.** | | | | | | | |
| 1 | Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг бий болгон, чадавхыг бэхжүүлэх | | | Төгсөлтийн дараах сургалтыг 2 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд явуулж байна. | Шинээр 3 бүсийн оношилгоо, эмчилгээний төвд төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна. | Төгсөлтийн дараах сургалтанд эх барих эмэгтэйчүүдийн үндсэн мэргэжил эзэмшсэн их эмч 19, төрөлжсөн мэргэшлийн эмэгтэйчүүдийн дотоод шүүрэл, үргүйдлээр их эмч 3, мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтанд дурангийн мэс заслын их эмч 2, эх барих эмэгтэйчүүдийн хэт авиан оношлогооны судлалын их эмч 5, нийт төгсөлтийн дараах сургалтанд 32 их эмч бэлтгэгдэн төгссөн. | 100% |
| 2 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлнэ. | | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Байхгүй | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | 2022 оны 3 дугаар улирлын байдлаар үр дүнгийн урамшуулалд **324.623.557** төгрөг олгосон байна.<br>“Эрүүл мэндийн ажилтны дэмжих сар” аяны хүрээнд 2022 оны 08-р сард цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тооцож, эмч, эмнэлгийн ажилтнуудад **59.947.323** төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал олгосон | 100% |
| **Зорилт 5.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ:** | | | | | | | |
| **5.3.1.Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно** | | | | | | | |
| 1 | Эмнэлгийн бүх хэсэгт WIFI нэвтрүүлнэ. | 99.0 Өөрийн орлого | Шинээр байршуулсан WIFI төхөөрөмжийн тоо | Байхгүй | 77ш WIFI төхөөрөмж суурьлуулж үйл ажиллагаанд оруулсан байна. | Юнител групптэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд эмнэлгийн бүх хэсэг 77 ширхэг WIFI төхөөрөмж суурилуулж үйл ажиллагаанд оруулсан. | 100% |
| 2 | Эмнэлгийн цахим бүртгэлийн системтэй болно. | 18.0 Өөрийн орлого | Карте цахим бүртгэлд орсон өвчтөний түүхийн тоо | Еклиник 100% нэвтрүүлсэн | Карте цахим бүртгэлд бүх өвчний түүхийг оруулдаг болсон байна | Карте цахим бүртгэлд эхний хагас жилийн байдлаар даатгалаар нэхэмжлэгдсэн 35699 үйлчлүүлэгчийн өвчний түүхийг оруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 5.6.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ:** | | | | | | | |
| **5.6.3.Төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог** боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1 | МУ-ын “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлнэ. | - | Хуулийн хэрэгжилтийн хувь | Хуулийн хэрэгжилт 95% байсан | Хуулийн хэрэгжилтийн хувийг 100%-д хүргэсэн байна. | Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих гүйлгээний мэдээлэл, тушаал шийдвэрүүд, жилийн төсвийг байршуулсан. | 100% |

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ Ц.БАТБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ Н.БАТСАЙХАН